



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
САЙХАН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 02 өдөр

Дугаар А/09

Онги

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 05 дугаар сарын 24-ны өдрийн 86 дугаар тушаалаар батлагдсан Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журмын 6.1, 6.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2024 онд хийгдэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөхөд арга зүйн зөвлөмж өгч дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Засаг даргын орлогч

Гишүүд: Засаг даргын тамгын газрын дарга

Төрийн сангийн мэргэжилтэн

Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн

Нийгмийн бодлогын асуудал хариуцсан мэргэжилтэн

Засаг даргын тамгын газрын Нягтлан бодогч


Соёлын төв тусгай сан хариуцсан нягтлан бодогч

Засаг даргын Тамгын газрын Нярав

2. Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээний жагсаалтыг гаргаж олон нийтийн дунд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулан олон нийтийн эрх ашигт нийцсэн, орон нутгийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөртэй уялдсан журмын 6.3, 6.4 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан нэгдсэн жагсаалтыг гарган танилцуулахыг ажлын хэсэгт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн А/11 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ЛУВСАНРАГВА

D disk /2024on/A Zahiramj.doc

482/01009

